

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар
сарын 25-ны өдрийн А/259 дүгээр
тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

2025 он

ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК

БАТЛАВ: ДЦС-4 ТӨХК-н гүйцэтгэх захирал

Ү.ТӨМӨРХУЯГ

ЗУУХ №1 ХАЛАХ ГАДАРГУУН ИХ ЗАСВАР АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалтын
нэр:

Тендер
шалгаруулалтын
дугаар:

ЗУУХ №1 ХАЛАХ ГАДАРГУУН ИХ ЗАСВАР

ДЦС4/20250101039

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	5
1. Тендерийн цар хүрээ.....	5
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	5
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж	5
4. Худалдан авах ажиллагааны цахим систем.....	5
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.....	5
6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага	5
7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага	6
B. АГУУЛГА	6
8. Тендер шалгаруулалтын баримт бичиг	6
9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах	6
10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	7
11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах	7
V. ТЕНДЕР БЭЛТГЭХ	7
12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл	7
13. Тендерийн иж бүрдэл.....	8
14. Тендерийн жишиг маягтууд	8
15. Хувилбарт санал	8
16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг.....	8
17. Чадавхын болон туршлагын шаардлага	9
18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ..	9
19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ..	10
20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.....	10
21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт.....	10
22. Тендерийн валют.....	11
23. Тендер хүчинтэй байх хугацаа	11
24. Тендерийн баталгаа	11
G. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ.....	11
25. Тендер баталгаажуулах, илгээх	11
26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	12
D. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	12

27.	Тендерийн талаар тодруулга авах	12
28.	Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	12
29.	Тендерийг үнэлэх	12
30.	Арифметик алдааг залруулах.....	12
31.	Давуу эрх олгох	13
32.	Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	13
33.	Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	13
34.	Тендерийг эрэмбэлэх	13
35.	Оролцогчийн чадавхыг дахин магадлах	13
E.	МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	13
36.	Мэдэгдэл хүргүүлэх	14
37.	Гүйцэтгэлийн баталгаа.....	14
38.	Урьдчилгаа төлбөр	14
39.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	14

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрднө.

4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан

байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаarahгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б.АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3.Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай

<p>баримт бичгийг тодруулах</p> <p>10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт</p> <p>11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах</p> <p>12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл</p>	<p>хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.</p> <p>9.2. Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.</p> <p>9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.</p> <p>9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.</p> <p>9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.</p> <p>10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.</p> <p>10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.</p> <p>11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.</p> <p>11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.</p> <p>11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.</p> <p>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</p> <p>12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.</p> <p>12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.</p> <p>12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.</p>
--	---

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

14. Тендерийн жишиг маягтууд

15. Хувилбарт санал

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн

17. Чадавхын болон туршлагын шаардлага

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

21.3. Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.4. ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5. ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг

“тендерийн үнэ” гэж үзнэ.

21.6.Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.7.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2.Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1.Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2.Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3.Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1.Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан

тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт 7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1. Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

29.2. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

29.3. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

30. Арифметик алдааг залруулах

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 36. Шийдвэр хүргүүлэх** 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 37. Гүйцэтгэлийн баталгаа** 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38. Урьдчилгаа төлбөр** 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.
- 38.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38.4. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах** 39.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 39.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	
ТШЗ-ны холбогдох заалт	
ТШЗ 1.1	Захиалагч: “Дулааны Дөрөөдүгээр Цахилгаан Станц” ТӨХК
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: зүүх №1 халах гадаргуун их засвар
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: ДЦС4/20250101039
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “ Үгүй ”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь өөрийн хөрөнгө
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 3,988,445,542.00₮
Б.АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: Худалдан авах хэлтэс Хаяг: УБ хот, БГДүүрэг, 20-р хороо, Эрчим хүчний гудамж, ДЦС-4 ТӨХК-н захирагааны төө байр, 3-н дахар, 310 тоот өрөө Утасны дугаар: 70171357, 70181309 Цахим шуудангийн хаяг: info@tpp4.mn
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “ Үгүй ”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “ Зөвшөөрөхгүй ”
ТШЗ 16.1.2	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана” Хэрэв шаардах бол хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу сонгож бичнэ. <ul style="list-style-type: none"> - Төлбөрийн чадвартай, татан буулгах шийдвэр гаргуулаагүй - Монгол Улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэргүй, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөргүй - Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасанаар Захиалагчтай харилцан хамааралгүй байх
ТШЗ 18.1	Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана” <ul style="list-style-type: none"> - Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2022, 2023 онуудын гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь он тус бүр батлагдсан төсвийн 100 хувиас багагүй байх

	<ul style="list-style-type: none"> - Түргэн хөрвөх хөрөнгө: Тендерт санал болгосон дүнгээс багагүй байх - Өр, төлбөртэй холбогдох шаардлага: Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт - Бусад шаардлага: Зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн түүхгүй байх
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <p>[ТШЗ 19.1-д зааснаар оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримтыг жагсаан бичнэ.]</p> <p>Хуулийн 16.2, 16.4-т заасан дараах баримт бичгээс сонгож шаардаж болох ба бусад баримт бичиг шаардахыг хуулиар зөвшөөрөөгүй болохыг анхаарна уу. Жишээлбэл:</p> <ul style="list-style-type: none"> - Сүүлийн 2022, 2023 онуудын баталгаажсан санхүүгийн тайлан; - Харилцагч банкны мэдэгдэл; - Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа; - Сүүлийн 2022, 2023 оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл. - Санхүүгийн тайландаа аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд санхүүгийн тайландаа хийсэн аудитын дүгнэлт.
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана”</p> <p>Хэрэв шаардах бол дор дурдсан шаардлагаас гэрээний үүргийн гүйцэтгэлд ач холбогдол бүхий шаардлыг тусгах ба үүсээр хязгаарлагдахгүй.]</p> <p>Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардана” /Хэрэв шаардах бол уг ажлыг гүйцэтгэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаар шаардах мэдээллийг тодорхой бичих/</p> <ul style="list-style-type: none"> - Ерөнхий инженер 1 /Гэрээнд заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх хугацаа: 3 жил /Түүний дотроос гэрээг хариуцаж ажилласан туршлагатай байх хугацаа: 2 жил/ - ХАБ-ын инженер 1 /хүчин төгөлдөр сертификатын хуулбар ирүүлэх/ - Тухайн ажлыг хийж байсан туршлага бүхий ИТА-ны тоо 3-аас доошгүй /ХАБ-ын инженер орохгүй/ - Аргон гагнуураар 1A категорын шугам хоолой гагнах зөвшөөрөлтэй гагнуурчдын тоо 3-с доошгүй байх /1A категорын шугам хоолой гагнах зөвшөөрөлтэй цахилгаан гагнуурчид орохгүй/ - Цахилгаан гагнуураар 1A категорын шугам хоолой гагнах зөвшөөрөлтэй гагнуурчдын тоо 3-с доошгүй байх/

	<ul style="list-style-type: none"> - Цахилгаан гагнуурчдын тоо 3-аас доошгүй 77 зэрэгээс дээш\ /1A категорын шугам хоолой гагнах зөвшөөрөлтэй аргон болон цахилгаан гагнуурчид орохгүй/ - Хагас автоматаар гагнах эрхтэй гагнуурчин 3-аас доошгүй байх /мэргэжлийн үнэмлэхний хуулбар ирүүлэх/ - Плазм огтлогч дээр ажиллах чадвар бүхий ажилтны тоо 3-аас доошгүй байх /мэргэжлийн үнэмлэхний хуулбар ирүүлэх/ - Оосорлогч дохиочин 3-аас доошгүй байх /мэргэжлийн үнэмлэхний хуулбар ирүүлэх/ - Өрлөг, дулаалгын ажилтны тоо 8-аас багагүй - Хийн огтлогчийн тоо 5-аас багагүй <p>Дээрх заасан ажилтнууд сүүлийн 1 жил тухайн байгууллагад ажилласан байх шаардлагатай бөгөөд үүнийг нотолсон бичиг заавал ирүүлэх ба энэ нь E-mongolia-с хүн тус бүрээр нийгмийн даатгалыг тухайн байгууллага төлсөн тодорхойлолт лавлагааг хавсарган баталгаажсан байх</p> <p>Нийт ажиллагсдын тоо 45-аас багагүй байх</p> <p>Нийт 45 ажилтны 80%-с багагүй нь сүүлийн 1 жил тухайн байгууллагад ажилласан байх шаардлагатай бөгөөд үүнийг нотолсон бичиг заавал ирүүлэх ба энэ нь НДШ-ээр баталгаажсан байх</p> <p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардана”/Хэрэв шаардах бол тухайн ажил гүйцэтгэхэд зайлшгүй шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд тавигдах шаардлагыг тодорхойлжсан баримт ирүүлнэ/</p> <ul style="list-style-type: none"> - Өргөх зөөх цахилгаан механизм /лебёдка/ 3-с доошгүй, гар таль 8-с багагүй /5тн-с багагүй даацтай 4ш/, шаардлагатай оосорлох хэрэгслэлтэй байх /паспорт, зураг, даац тодорхойлсон баримт ирүүлнэ/ - Олон цэгийн гагнуурын аппарат 2-оос доошгүй /хийх ажлын хэрэгцээнд хүрэлцээтэй байх, паспорт, зураг ирүүлнэ / - Хагас автомат гагнуурын аппарат 5-аас доошгүй /паспорт, зураг ирүүлнэ/ - Плазмаар огтлох аппарат 5-аас доошгүй /паспорт, зураг ирүүлнэ/ - Дотоод ачаа тээврийн машин, авто кран ТХ-ийн гэрчилгээ хуулбар /өөрийн эзэмшилийн бус бол гэрээт ажил дуустал ашиглах гэрээ/ ирүүлнэ - Хийн огтлох хэрэгсэл 5-оос багагүй /зураг ирүүлнэ/ - Хүчилтөрөгч болон пропаны баллон огтлогчийн тооноос багагүй байна - Битүү саванд ажиллах зориулалтын зөөврийн гэрлийн тоо 10-аас багагүй <p>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардана”</p> <p>Батлагдсан төсөөт өртгийн үнийн дүнгийн 80 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг сүүлийн 2 жилийн /2023, 2024 он/</p>
--	--

	<p>хугацаанд хийсэн байх. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн ажлын гэрээ, гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлэх</p> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”</p> <p>Хэрэгжүүлэх эрх авсан гэрээний тухай мэдээлэл захиалагчийн тодорхойлолт</p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: “Шаардахгүй</p>
ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <p>[ТШЗ 19.1-д заасан шаардлагыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичгийг хуулийн 17.2-т заасан баримт бичгээс сонгож бичнэ. Жишээ нь:]</p> <ul style="list-style-type: none"> - Шаардсан хүний нөөцийг мэдээллийг V бүлгийн маягтын дагуу ирүүлэх; - Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн 0, 0-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл; - Ажил гүйцэтгэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл, (өөрийн өмчлөл, эзэмшийн, түрээслэх гэх мэт);
ТШЗ 19.3	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана”</p> <p>ЭХЯ Т3-03.3.4 - 0.7-80.0 кгх/см2 болон түүнээс дээш даралттай зуухны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ</p>
ТШЗ 21.6	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: 19,942,228.00₮

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

ТШЗ 25.5	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ul style="list-style-type: none"> - ТБОНӨХБАУХА тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлага хангасныг нотлох баримт бичиг - Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэл - ТБОНӨХБАУХА тухай хуулийн 22.5 дугаар зүйлд заасан үндэслэлээр ил болгохгүй баримт бичиг, мэдээлэл байгаа бол түүнийг хууль зүйн үндэслэлийг тайлбарсан мэдэгдэл <p>[Ил болгох баримт бичгийг жасаан бичнэ үү.]</p>
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2025.02.13</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТШЗ 26.2	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.

	<p>Огноо: 2025.02.13 Цаг: 10 цаг 30 минут Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: УБ хот, БГДүүрэг, 20-р хороо, Эрчим хүчний гудамж, ДЦС-4 ТӨХК-н захиргааны төв байр, 310 тоот өрөө</p>
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 31.1	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: [ирийлэх шаардлагатай баримт бичгийг жагсаан бичнэ.]
ТШЗ 32.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”
Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 37.1	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Тийм” Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.
Ё. БУСАД	
ТШЗ 38.1	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй”

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

ДЦС-4 ТӨХК-ий БКЗ-420-140-10С маркын /станцын №1/ зуухны тоосон системийн засварын ажлыг өгөгдсөн эзлэхүүний дагуу энэ ажилд шаардлагатай материал, сэлбэг нийлүүлэн гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэх хугацаа **90** хоног.

Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа материал нь шинэ, ашиглагдаагүй, гэмтэл согоггүй, бөгөөд хамгийн сүүлийн үеийн, материалын хувьд зөрөөгүй, шаардлагатай зураг, техникийн тодорхойлолтод яв цав нийцсэн байх шаардлагатай.

Бараа материалын стандарт, үйлдвэрлэгчийн нэр заасан тохиолдол бүрд тухайн заагдсан бараа материал болон түүнтэй дүйцэхүйц байна гэж ойлгоно.

Өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бараа нийлүүлэхэд ашиглах бүх материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэрэг нь шинэ, сайн чанарын, зориулалтынх байна гэдгийг үйлдвэрлэгч, нийлүүлэгч баталгаажуулсан байна. Бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.

Нийлүүлэгдэх бараа нь ДЦС-4 ТӨХК-ий агуулах хүртэл хэвийн тээвэрлэгдэх сав баглаа боодолтойгоор Инкотермс-2010-т заагдсан DDP нөхцлөөр нийлүүлэгдэх бөгөөд патент худалдааны тэмдэг, зураг төслийн эрх г.м оюуны өмчийн эрхийн зөрчилгүй байна. Бараа нь тухайн инкотермсийн нөхцлийн дагуу даатгуулсан байна.

Гүйцэтгэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарь мөрдөнө. Хугацаа хоцуулан нийлүүлэхийг зөвшөөрөхгүй бөгөөд тендерээс татгалзах үндэслэл болно.

Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулга хувилбарыг хэрэглэнэ. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд зааснаар тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ.

Барааны баталгаат засвар нь бараа хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сарын хугацаанд хүчинтэй байна.

Гүйцэтгэгч гэмтэл согог илэрсэн тухай захиалагчийн мэдэгдэл хүлээн аваад гэмтэл соготой бараа, эсхүл түүний эд ангийг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино. Гэмтэл согог арилгаснаас хойш 12 сарын дотор засварласан бараанд энэ төрлийн гэмтэл согог дахин гарсан тухай бичгээр мэдэгдэл ирвэл уг гэмтэл согогийг үнэ төлбөргүй шуурхай арилгана. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй. Энэ зүйлд заасны дагуу нийлүүлэгчийн гаргах баталгаа нь гэрээнд заасан захиалагчийн бусад эрх, үйл ажиллагааг хязгаарлахгүй.

Гэрээнд хэрэглэсэн худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дах Олон улсын худалдааны танхимаас боловсруулан гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал, тэдгээрийг турших стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ. Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй дүйцэх, эсхүл түүнээс илүү чанартай олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад стандарт, кодыг хүлээн зөвшөөрнө.

Заасан стандарт болон санал болгосон стандартын хооронд ялгаагүй болохыг нийлүүлэгч бичгээр тодорхойлон гаргаж ирүүлнэ.

Техникийн тодорхойлолтод нэр заагдсан бараа материалын дэлгэрэнгүй тодорхойлолтыг чухал шаардлагатай сэлбэг эд ангиудын хувьд заавал ирүүлнэ. Үүнд: Ердийн байнга ашиглагддаг хийцийн эд ангиудаас бусад шаардлага онцгой тавигддаг материалуудыг ойлгоно.

- -Бүх төрлийн труба,
- -Шугам хоолойн хэлбэртэй эд ангиуд,
- -Халуунд ажиллах хийц хийх лист цувималууд г.м

Зураг төсөл, загвар зураг

БАТЛАВ. "ДЦС-4" ТӨХК-ИЙН

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

П.БОЛДБААТАР

2025 он 01-р сарын 03

Зуух №1 халах гадаргуун их засварын ажлын эзлэхүүн
(Гадны гүйцэтгэгчээр хийлгэх)

№	Драйлгаарын нэр	Хэмжээний нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
Зуух №1 Тийдсон тоноглолт				
Зуух №1-н Цахилгаан шүүлтүүрийн систем				
Зуух №1-н Цахилгаан шүүлтүүрийн системийн Каркас				
1	Дулалга хийх эхгүүдэд, шат барих, буулгах	м2	150	
2	Гарах талын узваны хийн сувгийн напуу болон хана, шалны хий соронт устахаа оруулсан (лист Сталь 6-8мм/	тн	1.290	
3	Орох талын узваны хийн сувгийн напуу болон хана, шалны хий соронт устахаа оруулсан (лист Сталь 6-8мм/	тн	1.728	
4	Засварын линзы доторлогдох хийх. Лист Сталь 6-8мм/	кг	400	
5	Дулалгын нимгэн темпер хуулгах	м2	30	
6	Дулалга хуулж авах, буулгах, хийх	м3	4.65	
7	Оценковый пистолет темперлах	м2	30	
8	Шат тавцан буулгах, авах	м3	150	
9	Орох болон гарах талын узваны хийн сувгийн дээвэрт дээвэр дунддын хүчинтийн темпереэр хичих	шархаг	28	
Зуух №1-н Цахилгаан шүүлтүүрийн системийн Каркас-н Их бие				
10	Дулалга хийх эхгүүдэд шат барих, буулгах	м2	150	
11	ЦШ-ийн их бийайн наагт бусыг армлах	ком	1	
12	Дулалгын нимгэн темпер хуулгах	м2	90	
13	Дулалга буулгах, хуулж авах, хийх	м3	11.62	
14	Оценковый листолет темперлах	м2	40	
Зуух №1-н Узваны хийн систем				
Зуух №1-н Узваны хийн шугам хослой				
Зуух №1-н Узваны хийн суваг				
15	Узваны хийн сувгийн засвар срок хоссаж шат тавцан барих буулгах	м2	80	
16	Зуухын суулгийн хэслийн узэс агаарын тусгасврлагч хана оруулсан хийх	тн	0.72	
17	Зуухын суулгийн хэслэс гарсан узваны хийн сувагт үзэг хийх цэвэрхийд оруулсан хийх	тн	1.152	
18	Зуухын суулгийн хэслэс цахилгаан шүүлтүүрний компенсатор-ийн авахаа хуртлагх узваны хийн суулгийн дулалга хийх	м3	12	
Зуух №1-н Тусгай зориулалтын тоноглолтууд				
Зуух №1-н Үүрэн температурын тохицууллын тоноглолт				
Зуух №1-н Влрыскийн узэль				
19	Солигдох хэслэйн дулалга буулгах шинээр хийх 430м2	м3	11	
Зуух №1-н Агаар халваагч				
Зуух №1-н Агаар халваагч I чу				
Зуух №1-н Агаар халваагч I чу-н куб				
20	Агаар халваагчад үзэг хийх замийн их гамталтайт кубаар нь солиж	тн	22	
21	Цонх парлагх буцааж ганнах	тн	0.3	

22	Цонх гаргасан хөслийн дурсалга буулгах хийр-12м2	м3	2.5	
23	Шал барих буулгах хийр	м2	10	
Зуух №1-н Уур халаагч				
Зуух №1-н Уур халаагчийн IV чу				
Зуух №1-н Уур халаагчийн IV чу-и пакет				
24	Хайрцамжийн дурсалга, нэгтгүүлэг буулгах, хийр	м3	4	
Зуух №1-н Уур халаагчийн III чу				
Зуух №1-н Уур халаагчийн III чу уур хөргөгчийн II үеийн хөргөх замер				
25	Уур хөргөгчийн 2-р чу коллекторд, орсон соллонтуудыг авч цэвэрлэх	ширэг	2	
26	Уур хөргөгчийн 2-р үеийн соллонны донышах авч, дахин галнах, мөтэллын шинжилгээний ингэлтийн хийр	ширэг	3	
Зуух №1-н Уур халаагчийн III чу-и пакет				
27	Хайрцамжийн дурсалга, нэгтгүүлэг буулгах, хийр	м3	4	
Зуух №1-н Уур халаагчийн II чу Ширмыг				
Зуух №1-н Уур халаагчийн II чу Ширмыг арын ширмийн пакет				
28	Ширмийн уур халаагчид хөжим зузаан, зууванжилт хэмжээх, хийд талын 90 градусын булагтавас 2 ширэг сорьц авч булагийн шинжилгээ хийр, 10ш пакетад 200 ш булан 200 шүлтүн хэсэгт нийт 400 цагт ингэлтийн хийр	дк2	100	
29	Ширмийн уур халаагчийн хөнчэр сергээж засварлах, таийсан труба солиж	тн	3	
30	Засарт шавьралагатай шат тавцан барих, буулгах	м2	60	
31	Хөнчэр сергээж засварлах,	яг	1280	
Зуух №1-н Уур халаагчийн II чу Ширмыг уур хөргөгчийн I үеийн хөргөх замер				
32	Уур хөргөгчийн 1-р үеийн соллог авч үзлэг хийр, галнах	ширэг	4	
33	Уур хөргөгчийн 1-р үеийн коллекторт ингэлтийн хийр МСГЛ-д шалгуплах	дк2	1	
34	Соллоны биттуу гаргах засварлах	ширэг	4	
35	Соллоны донышах шинээр хийр	тн	0.04	
Зуух №1-н Уур халаагчийн II чу Ширмыг нуурний ширмийн пакет				
36	Ширмийн уур халаагчид хөжим зузаан, зууванжилт хэмжээх, 2 ш сорьц авч булагийн шинжилгээ хийр, 10ш пакетад 200 ш булан 200 шүлтүн хэсэгт нийт 400 цагт ингэлтийс	дк2	100	
37	Ширмийн уур халаагчийн таийсан труба солиж	тн	3	
38	Засарт шавьралагатай шат тавцан барих, буулгах	м2	60	
39	Хөнчэр сергээж засварлах	яг	1280	
Зуух №1-н Уур халаагчийн I чу				
Зуух №1-н Уур халаагчийн I үеийн галлагаваны уур хөргөгчийн хөргөх замер				
40	Галлагаваны уур хөргөгчийн соллог авч үзлэг хийр, галнах	ширэг	2	
41	Галлагаваны уур хөргөгчийн коллектор 2 ширэг сорьц авах	ширэг	2	
42	Соллоны биттуу гаргах засварлах	ширэг	2	
43	Соллоны донышах шинээр хийр	тн	0.04	
Зуух №1-н Уур халаагчийн I үеийн гарах шутам				
Халуун хайрцааг дэхь УХ-1 чуус галлагаваны Галлагаваны уур хөргөгч зүртэй Ф150X13 мянган шугаанд, шат тавцан барихаа буулгах				
44	Ф150X13 мян-н шугамаас 2 ширэг сорьц авах	ширэг	2	
45	Ф150X13 мян-н 20 ширэг булагтуудад ингэлтийн хийр МСГЛ-д шалгуплах	дк2	40	
46	Ф150X13 мян-н 40 ширэг булагтуудад ингэлтийн хийр МСГЛ-д шалгуплах	дк2	40	
47	Уур халаагчийн I, нуурний болон арын ширм, II, IV үеийн нептрууллын хайрцамжийн бетоныг буулгах, сергээн дүүргэлт хийр	м3	10	

49	Уур халаагчийн I, нүүрний болон арын ширүү, III, IV үеийн нийтруулгын хайрцлагийг буулгах шинээр хийх	тн	0.846	
Зуух №1-н Уур халаагчийн Гүй-н пакет				
50	Уур халаагчийн 1-р үеийн змеевык хоорондын сям, хийнчар, хөндлөн голсын шинээр хийх, энгийнрүүлэгт хийх	кг	1500	
51	Уур халаагчийн 1-р үеийн змеевык хоорондын цахварталгаа хийх	м3	5	
52	Уур халаагчийн 1-р үеийн змеевык хоорондын цахварталгаа хийхад шаардлагатай шат барих, буулгах	м2	40	
53	Уур халаагчийн 1-р үеийн голын хотол дэхь шутам хохойнуудын орех, гарах талын шугам хохойнуудаас тус бүр 1 ширэгээ дэхжээ мөтэлэн бичил бутцийн шинжилгээ хийлгэх, Уур халаагчийн 1-р үеийн голын хотол дэхь 446 цэцт ханын буздан, зүйлэхийнгээ хөмөөнүүлэх	дм2	112	
Зуух №1-н Буух хөндийн уур халаагч				
Зуух №1-н Буух хөндийн уур халаагчийн пакель				
54	БХУХ-ын орох талын цонх ууцгадаг хослын үнсий хиймэлжилт солих	тн	0.5	
55	Засварт шаардлагатай шот тавцан барих, буулгах	м2	25	
56	БХУХ-ийн трубанд үзэгж хийж илэрсан гамтэл үстэх	тн	0.3	
57	Уур халаагчийн орох, гарах талын дренажийг буулгах, буудаж байрлуулж гамтэх	тн	0.6	
58	Коллекторын уг ангилэх	дм2	20	
59	Дранажийн шутамын дулаалга буулгах хийх	м3	1	
Зуух №1-н Экран				
Зуух №1-ийн Экранаас гарах шутам				
Зуух №1-ийн Дээд коллекторосс барабан хуртлзх шутам				
60	Үзэгж хийсэд шаардлагатай шот тавцан баруулж буулгах	м2	60	
61	Экраны доод, коллекторосс барабан руу холбогдосон Ф159х14-мийн шутам хослойн 84 булан, 42 ширэг гамтнүүрэн обропд өнгөтөө хийж МСГЛ-сөр шалтуулж, 18 ширэг сарьц авах	дм2	620	
62	2 ширэг буланг авч МСГЛ-сөр шинжилүүлэх, шинээр буланг байрлуулж гамтах /125 кг+130кг/	тн	0.265	
63	Дулаалга буулгах, шинээр хийх	м3	3	
Зуух №1-н Холодный воронка				
Зуух №1-н Холодный воронка-н өрлөг				
64	Хүйтэн воронкын хормойны лист солих /б-бым лист, 12X18N10T Ø6/	тн	0.852	
65	Хүйтэн воронкын нурууны лист солих /б-бым лист/	тн	0.3	
66	Хүйтэн воронкын өрлөгийн тавцур лист солих /б-бым лист/	тн	0.576	
67	Засварт шаардлагатай шот барих, буулгах	м2	10	
68	Хүйтэн воронкын өрлөг буулгах, хийх	м3	8	
Зуух №1-н Горелка				
Зуух №1-н Горелка дээд ярус				
69	Солигдох ад антиудийг хийнтуулж, болдаж	тн	0.76	
70	Горелкын тоос агаарын сувгийн хажуу шанханы цорсож эхийнгээ оруулж хийж засварлаж	тн	0.76	
Зуух №1-н Горелка дунд ярус				
71	Горелкийн тоос агаарын сувгийн деформацийд, орсон хэсгийг солиж	тн	0.76	
72	Солигдох ад антиудийг хийнтуулж, болдаж,	тн	0.76	
Зуух №1-н Горелка доод ярус				
73	Дотоод үзэгж илэрсан экраны гамтад оруулга оруулах	тн	0.2	
74	Горелкийн тоос агаарын сувгийн деформацийд орсон хэсгийг солиж	тн	0.76	

75	Солигдох эд аngиудийг хайчуулж, балдах	тн	0.76	
76	Засварын ажилд шаардлагатай шат тавцан барих, буулгах.	м2	20	
	Зуух №1-н Зүүн экран			
	Зуух №1-н Зүүн экраны панель			
77	Засвар хийхэд шаардлагатай шат тавцан баруулах буулгах	м2	60	
78	Солигдсон экраны гагнуурын оёдол өнгөлөх, МСГЛ-р гагнуурын оёдол шалгуулах	ширхэг	256	
79	Экраны татуурганд бахзлээг хийх	ширхэг	12	
80	Экраны дулаалга буулгах, шинээр хийх	м3	37.13	
81	Тэмдэгт 10-21 хүртэл (орчмын гагнуурын оёдолоос) экраны Ф60х6 Ту Ст-20 маркийн 11000 мм-ийн урттай трубаг буулгах, урдчилан бэлдсэн 11000 мм-ийн урттай панелүүд, маталттай болон шулуун экраныг МЦ-с зөвж байрлуулж гагнах	тн	12.3	
82	Горелка болон шагайвруудын бетон буулгах шинээр хийх	м3	2.5	
83	Горелка болон шагайвруудын хайрцаг буулгах шинээр хийх	тн	0.87	
84	ҮҮТ ба түүний (обдувка) хайрцаг авах буцааж байршуулах	ширхэг	3	
85	Ажлын байран дээр панель хоорондын полоса гагнах	м	500	
86	Донешка авч цэвэрлэн буцааж гагнах	ширхэг	8	
87	Экраны тэм-10-21 балка тэгшлэх, бэхлэх, гагнах	тн	0.7	
88	Экраны тэм-10-21 балканд бэхлэгдэх чих, косынька, швэллер шинээр хийж гагнах	тн	1.1	
89	Балка болон горелканы хайрцагны сухарка гагнах	ширхэг	48	
	Зуух №1-н Баруун экран			
	Зуух №1-н Баруун экраны панель			
90	Засвар хийхэд шаардлагатай шат тавцан баруулах буулгах	м2	60	
91	Солигдсон экраны гагнуурын оёдол өнгөлөх, МСГЛ-р гагнуурын оёдол шалгуулах	ширхэг	256	
92	Экраны татуурганд бахзлээг хийх	ширхэг	12	
93	Экраны дулаалга буулгах, шинээр хийх	м3	38.3	
94	Тэмдэгт 10-21 хүртэл (орчмын гагнуурын оёдолоос) экраны Ф60х6 Ту Ст-20 маркийн 11000 мм-ийн урттай трубаг буулгах, урдчилан бэлдсэн 11000 мм-ийн урттай панелүүд, маталттай болон шулуун экраныг МЦ-с зөвж байрлуулж гагнах	тн	12.3	
95	Горелка болон шагайвруудын бетон буулгах шинээр хий-10м2	м3	2.5	
96	Горелка болон шагайвруудын хайрцаг буулгах шинээр хийх	тн	0.87	
97	ҮҮТ ба түүний (обдувка) хайрцаг авах буцааж байршуулах	ширхэг	3	
98	Ажлын байран дээр панель хоорондын полоса гагнах	м	500	
99	Донешка авч цэвэрлэн буцааж гагнах	ширхэг	8	
100	Экраны тэм-10-21 балка тэгшлэх, бэхлэх, гагнах	тн	0.7	
101	Экраны тэм-10-21 балканд бэхлэгдэх чих, косынька, швэллер шинээр хийж гагнах	тн	1.1	
102	Метал хийц бэлдэх	тн	1.8	
	Зуух №1-н Баруун экраны доод коллектор			
103	Засвар хийхэд шаардлагатай шат тавцан баруулах буулгах	м2	10	
104	Солигдоогүй улдаж буй хэсгүүдийн дээд, доод талаас буюу хана тус бүрээс 2 ширхэг сорьц авч МСГЛ-т шинжлүүлэх, Сорьц авсан хэсэгт оруулга оруулах гагнуурын оёдол өнгөлж шалгуулах	ширхэг	8	
105	Экраны дулаалга буулгах, шинээр хийх	м3	2.5	
106	Хүчлийн угаалганд шаардлагатай уурын шугам татах Ф32х4, буцааж авах	тн	0.15	
107	Хүчлийн угаалганд шаардлагатай агаарын шугам татах Ф20х4, буцааж буулгах	тн	0.15	

108	Хүчлийн угаалгын емне ба дараа баруун, зүүн, ар, нүүрний, экраны заагдсан хэсгээс сорьц авах, экраны трубанд оруулга хийж гагнах	тн	0.08	
